



## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 57227

Улаанбаатар хот

### М.Бадамсүрэнд сахилгын шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.8, 48 дугаар зүйлийн 48.1.4 дэх заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.1.8 дахь заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 3.4.4, 3.4.5, 6.1 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.1, 10.4, 10.9, 10.10.5, 10.10.11 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Мягмардоржийн Бадамсүрэн нь улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгтээ хариуцлагагүй хандсан болох нь хяналтын улсын байцаагчийн 2023 оны 1295 дугаар дүгнэлт, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөр тасалбар болгон төрийн албанаас халах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. М.Бадамсүрэнгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг цуцлахыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар /Б.Ариунболд/-т даалгасугай.

3. Төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг гаргуулж, холбогдох хууль тогтоомжийг сануулахыг нууц хамгаалах ажилтан /Г.Анхныбаяр/-д үүрэг болгосугай.

4. М.Бадамсүрэнгийн холбогдох тооцоог хийж дуусган, үүрэгт ажлыг зохих журмын дагуу хүлээлцэж, 244 дугаартай улсын бүртгэгчийн тэмдгийг хураан авч түр хадгалахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /С.Оюун-Эрдэнэ/-т, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

5. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН